



НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨРИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 4/06

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.3.10, 8.4 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын хөдөлмөр эрхлэлтийн бодлого чиг хандлагыг тодорхойлж, ажилгүйдлийн зураглал гаргах судалгааны ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, удирдамжийг 2 дугаар хавсралтаар, асуулгыг 3 дугаар хавсралтаар, төсвийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Судалгааг удирдамжийн дагуу явуулж, хэрэгжилтийн байдалд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /Д.Оюунгэрэл/-д даалгасугай.


3. Судалгаанд шаардагдах мөнгөн хөрөнгийг гаргахыг нягтлан бодогч /О.Одхүү/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙН ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Н.ТУНГАЛАГ

Нийслэлийн хөдөлмөрийн газрын
даргын 2014 оны 0 дүгээр сарын 02-ны
өдрийн 14/сү тоот тушаалын 1.-р хавсралт




АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч Д.Оюунгэрэл

Гишүүд Ц.Бямбасүрэн
 Д.Эрдэнэбилэг
 Б.Гүнчинхүү
 С.Уугантуяа
 Г.Ганзориг
 Н.Одонтуяа
 У.Баттуяа

Нийслэлийн хөдөлмөрийн газрын
даргын 2014 оны дүгээр сарын 12-ны
өдрийн А/С тоот тушаалын 2-р хавсралт



УЛААНБААТАР ХОТЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БОДЛОГО ЧИГ ХАНДЛАГА, АЖИЛГҮЙДЛИЙН ЗУРАГЛАЛ ГАРГАХ СУДАЛГАА

Зорилго

Улаанбаатар хотын хөдөлмөр эрхлэлтийн бодлого чиг хандлага, ажилгүйдлийн зураглал гаргах, өрхийн үйлдвэрлэл, жижиг бичил бизнес эрхлэх боломж нөхцөл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход оршино.

Зохион байгуулах байгууллага

- ✦ Нийслэлийн Хөдөлмөрийн газар
 - ✦ Төвийн 6 дүүргийн хороод
3. Иргэдийн мэдээлэл цуглуулах ажил эхлэхээс өмнө дараах бэлтгэлийг хангасан байна.
- Дүүрэг хороодыг сонгох
 - Иргэдээс авах санал асуулга маягтийг бэлтгэх
 - Төсвийг хуваарилах, зарцуулах
 - Хэсгийн ахлагчдыг мэдээллээр хангах
 - Дүн мэдээг мэдээллэх, тайлан, илтгэх хуудсыг баталгаажуулах
 - Гэрээт судалгааны ажилтнуудад сургалт явуулах
 - Бусад цаг үеийн асуудал
4. Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд
- Мэдээлэл цуглуулах хэсгийн ахлагчдын ажиллах чиглэл
 - Хяналтаар ажиллах гишүүдийн хуваарь гаргах
 - Хэсгийн ахлагчдын нэрс, холбоо барих утас болон бусад мэдээллийг бүрдүүлэх

Зохион байгуулах хугацаа

2014 оны 4 дүгээр сарын 01-нээс 9 дүгээр сарын 01 –ны хооронд

Судалгааны арга зүй

Судалгааг хөдөлмөр эрхлэлтийн дэмжих чиглэлээр одоогийн хэрэгжиж буй бодлогын баримт бичиг, хууль эрх зүйн орчин, авч буй арга хэмжээ, олон улсын туршлагын хүрээнд эмпирик судалгаа болон статистик шинжилгээ, эконометрикийн загвараар прогнолох, түүвэр судалгаа, өрхүүдээс авах, ярилцлагад тулгуурлан хийнэ. Судалгаанд дараах арга, аргачлалуудыг ашиглана. Үүнд

- ҮСГ-аас 2007 онд гаргасан "Тооллого, түүвэр судалгаа, үзлэг явуулах нийтлэг журам"-ыг баримтлан нийгмийн халамж, бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт болон бэлэн бус хэлбэрээр үзүүлж буй төрийн үйлчилгээний сэтгэл ханамжийн талаар түүвэр судалгааг системчилсэн түүврийн аргаар явуулна. Түүврийн хэмжээг байгууллагуудын профайлыг тодорхойлсны дараа судалгааны баг тооцоолж гаргана. Түүврийн 0,05 буюу итгэх магадлал нь 95 хувьтай байхаар хийнэ алдааг.
- Түүвэр судалгааны төлөвлөх, зохион байгуулах, асуулгын болон түүврийн зохиомж боловсруулах, үндсэн мэдээлэл цуглуулах, үр дүнг тархаах, нэгтгэх бүхий л үе шатыг дэс дараатайгаар баримтлан ажиллаж, нэгтгэн боловсруулалт хийнэ.
- Ярилцлага нь зорилтот сегментийн зан төлөвийг нарийвчлан судалж, судалгаанд шаардлагатай нэмэлт мэдээллийг цуглуулах, анкетын судалгаанд хариулсан тодорхойгүй зарим учир шалтгааныг тодруулахад чиглэгдсэн байна.

Хамрах хүрээ:

- Төвийн 6 дүүргийн өрхүүд

Зохион байгуулж буй байгууллагуудын оролцоо

Нийслэлийн Хөдөлмөрийн газар

- Нийслэлийн гэр хорооллын иргэдийн бизнес эрхлэх сонирхол хэрэгцээ шаарлага орлогыг тодорхойлох үйл ажиллагааг зохион байгуулах удирдамж, төлөвлөгөө, төсөв гарган батлуулж, хэрэгжүүлэх
- Хороодын дарга нартай хамтран хэсгийн ахлагч нарт нэгдсэн удирдамж, чиглүүлэлтийг өгөх
- Нийслэлийн төвийн түүвэр судалгаанд 6 дүүргийн 30 хорооны 30 хэсгийн ахлагч, 60 гэрээт ажилтан ажиллуулахаар тооцон хуваарилах, хэсгийн ахлагч, гэрээт ажилтнуудын 1 өдрийн ажлын хөлсийг үр дүнг харгалзан 10000 төгрөг байхаар тооцож ажлыг зохион байгуулах
- Батлагдсан маягтыг хуваарилах
- Нийслэлийн хөдөлмөрийн газар нь судалгааны явцын хяналт тавьж, мэдээллийг нэгтгэнэ.

Хороодын дарга нар

- Хороодын дарга нар хэсгийн ахлагчид заавар зөвлөгөө өгч, хяналт тавин ажиллах
- Хэсгийн ахлагчийн цуглуулсан мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж, баталгаажуулах.
- Хэсгийн ахлагчийн хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс гарах гомдол, саналыг барагдуулах.
- Хэсгийн ахлагчийн оруулсан мэдээллийн үр дүнгээр урамшууллыг олгох.

- Ажилгүй иргэн болон бизнес хийх сонирхолтой иргэдийн судалгааг авч, Нийслэлийн Хөдөлмөрийн газрын мэргэжилтнүүдэд хүлээлгэж өгөх

Хэсгийн ахлагч

- Хэсгийн ахлагч нь Хөдөлмөрийн газар / Хорооны даргын шууд удирдлага дор ажиллана.
- Хэсгийн ахлагч нь тухайн хорооны иргэдийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүй байгаа шалтгаан, өрхийн үйлдвэрлэл, жижиг бичил бизнес эрхлэх боломж нөхцөл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох
- Хэсгийн ахлагч нь аюулгүй байдлаа хангах ажиллах
- Хэсгийн ахлагч нь бүртгэсэн мэдээллээ хорооны дарга болон Нийслэлийн Хөдөлмөрийн газрын ажилтнуудад хянан шалгуулж, баталгаажуулах.
- Хэсгийн ахлагч нар ажлын үр дүнгээрээ урамшуулах авах
- Судалгааг үнэн зөв гаргах


Хүрэх үр дүн

Улаанбаатар хотын хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, ажилгүй иргэдийн мэдээллийг цуглуулж судалгааны сан бүрдүүлсэн байна.

Тайлан мэдээ

Судалгаа явагдаж дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор тайлан мэдээг нэгтгэн холбогдох газруудад хүргүүлнэ.

Нийслэлийн хөдөлмөрийн газрын
даргын 2014 оны 3 дүгээр сарын 4-ны
өдрийн А/10 тоот тушаалын 3...-р хавсралт




Судалгааны анкет

Улаанбаатар хотын иргэдийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүй байгаа шалтгаан, жижиг бичил бизнес эрхлэх боломж нөхцөл, хэрэгцээ шаардлагыг тодруулах зорилгоор энэхүү судалгаа явуулж байна. Та үнэн зөв бөглөж өгнө үү

Ерөнхий төлөв	<p>1. Таны нас <input type="text"/></p> <p>2. Ам бүлийн тоо <input type="text"/></p> <p>3. Өрхийн орлого хэд вэ? / төгрөг/</p> <p>1) 192,000-350,000 2) 350,000-500,000 3) 500,000-700,000 4) 700,000-900,000 5) 900,000 дээш</p> <p>4. Таны хөдөлмөр эрхлэлтийн байдал</p> <p>1) Ажилтай /асуулт 7 руу/ 2) Ажилгүй</p> <p>5. Хөдөлмөр биржид бүртгэлтэй эсэх</p> <p>1) Тийм 2) Үгүй</p> <p>6. Таны ажилгүй байгаа шалтгаан ?</p> <p>a) Гадаадаас ирээд ажилгүй байгаа b) Гэртээ хүүхдээ хардаг /..... хүүхдийн нас/</p> <p>c) Эрүүл мэндийн шалтгаанаар d) Ажил хийх сонирхолгүй e) Ажил хайж байгаа</p> <p>f) Бусад...../ бичнэ үү/</p> <p>7. Таны орлогыг их үүсвэр юу вэ?</p> <p>a) Өөрийн цалин b) Өрхийн гишүүний цалин c) Мод нүүрс зардаг орлого</p> <p>d) Халамжийн мөнгө f) Бусад/бичнэ үү/</p> <p>8. Та доорхи аль ажил эрхлэлтийн байдлыг сонирхож байна вэ?</p> <p>1) Хувиараа хөдөлмөр эрхлэх 2) Байнгын ажлын байранд зуучлуулах 3) Түр ажлын байранд зуучлуулах</p> <p>9. Та ямар ажил эрхлэдэг вэ</p> <p>..... /бичнэ үү/</p>
Бичил зээл авах сонирхол	<p>10. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн болон бичил зээлд хамрагдаж байсан эсэх ?</p> <p>1) Тийм 2) Үгүй</p> <p>11. Бичил зээлд хамрагдах сонирхол байна уу?</p> <p>1) Тийм 2) Үгүй / асуулгыг дуусгана/</p> <p>12. Бичил зээлийн хэмжээ хэд байвал болох вэ?</p> <p>1) 3-5 сая төгрөг 2) 6-9 сая төгрөг 3) 10 саяаас дээш</p> <p>13. Зээлэнд хамрагдахад тулгарч буй хүндрэл бэрхшээл юу байна вэ?</p> <p>a) Барьцаа хөрөнгө шаарддаг b) Бүрдүүлэх бичиг баримт олон c) Эргэн төлөх хугацаа богино d) Хүү өндөр e) Мэдээлэл багатай байдаг f) Бусад/бичнэ үү/</p> <p>14. Зээлэнд хамрагдахаар болвол ямар үйл ажиллагаа эрхлэнэ гэж бодож байна вэ?</p> <p>...../бичнэ үү/</p>

Танд баярлалаа

Нийслэлийн Хөдөлмөрийн газрын даргын
2014 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн
тоот тушаалын 100-р хавсралт



УЛААНБААТАР ХОТЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БОДЛОГО ЧИГ ХАНДЛАГА,
АЖИЛГҮЙДЛИЙН ЗУРАГЛАЛ ГАРГАХ СУДАЛГААНЫ ТӨСӨВ

Зардлын утга	Тоо хэмжээ	Үзэгж үнэ	Хугацаа	Нийт
Судалгааны ажлын хэсгийн ахлагчийн урамшуулал	1	150000	5 сар	750000
Судалгааны ажлын хэсгийн гишүүдийн урамшуулал	7	100000	5 сар	3500000
Зөвлөх эрдэмтний ажлын хөлс	1	2000000		2000000
Асуулгын хуудас	5000	200		1000000
Гэрээт судалгааны ажилтны хөлс	90	10000	4 өдөр	3600000
Хавтас	100	1500		150000
Бал	100	400		40000
Дэвтэр	100	1000		100000
Шатахууны зардал	500	1800		900000
Судалгааны гэрээт ажилтны сургалт болон бусад зардал	1	1500000		1500000
Нийт				13540000